



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/161/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт.....	14
4.2 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

АДГАА 02.16 № 2/69

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0050?0382

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is fluid and extends across the stamp.

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53,390,844.00	66,989,728.50
35	БАРАА МАТЕРИАЛ	53,390,844.00	66,989,728.50
351	Түүхий эд материал	10,312,899.00	18,316,861.00
35110	Тусгай зориулалттай материал	9,161,299.00	14,493,461.00
35130	Эм боох материал	1,151,600.00	3,823,400.00
354	Хангамжийн материал	43,077,945.00	48,672,867.50
35410	Бичиг хэргийн материал	5,461,160.00	2,040,650.00
35420	Аж ахуйн материал	14,898,095.00	13,422,748.00
35460	Хүнсний материал	182,990.00	5,658,969.50
35470	Бусад хангамжийн материал	22,535,700.00	27,550,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,066,516,036.04	2,031,745,771.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,066,516,036.04	2,031,745,771.35
392	Биет хөрөнгө	1,948,796,286.04	1,914,059,021.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,976,895,452.94	1,976,895,452.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,971,293.49	-92,471,689.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,196,988.00	47,221,988.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,971,413.42	-31,500,746.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,788,209.98	44,168,209.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,439,707.97	-32,232,743.05
39217	Ном	1,298,050.00	1,978,550.00
393	Биет бус хөрөнгө	117,719,750.00	117,686,750.00
39301	Програм хангамж	780,000.00	780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-535,250.00	-568,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	117,475,000.00	117,475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,119,906,880.04	2,098,735,499.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	101,454.70	254,357.41
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	101,454.70	254,357.41
413	Өглөг	101,454.70	254,357.41
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	101,454.70	249,408.41
4136	Бусад өглөг	00.00	4,949.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	4,949.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,119,805,425.34	2,098,481,142.44
51	Засгийн газрын хувь оролцоо	2,119,805,425.34	2,098,481,142.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	257,455,541.08	257,455,541.08
51101	Өмч: - төрийн	257,455,541.08	257,455,541.08
512	Хуримтлагдсан үр дүн	1,386,058,964.44	1,364,734,681.54
51210	Өмнөх үеийн үр дүн	1,386,058,964.44	1,386,058,964.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-21,324,282.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	476,290,919.82	476,290,919.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,119,906,880.04	2,098,735,499.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	562,687,800.00	565,712,027.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,388,500.00	13,114,712.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,388,500.00	13,114,712.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,388,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,388,500.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө		2,275,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал		10,839,712.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	557,299,300.00	570,399,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	425,807,700.00	438,908,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	425,807,700.00	438,908,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,819,700.00	12,032,140.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,858,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,819,700.00	8,174,140.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	106,671,900.00	101,656,875.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,671,900.00	101,656,875.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	595,290,677.18	587,036,309.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	595,290,677.18	587,036,309.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,784,245.18	555,746,791.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,119,775.00	319,258,174.21
210101	Үндсэн цалин	241,951,675.00	259,452,423.21
210102	Нэмэгдэл	41,199,300.00	34,069,651.00
210104	Урамшуулал	23,968,800.00	25,736,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,758,222.65	42,294,820.81
210201	Тэтгэврийн даатгал	26,653,145.80	29,547,469.81
210202	Тэтгэмжийн даатгал	3,133,984.12	3,303,869.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,490,389.61	2,572,538.00
210204	Ажилгүйдлийн даатгал	589,153.36	624,630.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,891,549.76	6,246,314.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,934,374.00	100,156,875.00
210301	Гэрэл, цахилгаан	3,310,458.00	3,055,190.00
210302	Түлш, халаалт	89,559,500.00	89,259,269.00
210303	Цэвэр, бохир ус	10,064,416.00	7,842,416.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,212,036.52	13,590,987.00
210401	Бичиг хэрэг	717,520.50	783,410.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.02	664,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	751,108.00	1,042,800.00
210404	Ном, хэвлэл	4,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,004,208.00	3,716,357.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	7,054,420.00
2105	Нормативт зардал	39,405,805.60	30,329,539.50

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	763,480.00	3,290,000.00
210502	Хоол, хүнс	37,263,975.60	25,445,339.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,378,350.00	1,594,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,014,300.00	3,832,850.00
210604	Урсгал засвар	2,014,300.00	3,832,850.00
2107	Томилолт, зочны зардал	36,000.00	160,000.00
210702	Дотоод албан томилолт	36,000.00	160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	858,658.00	1,559,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	558,658.00	1,044,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,445,073.41	44,563,944.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	518,100.00	1,846,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,492,300.00	2,861,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,434,673.41	39,855,764.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,506,432.00	31,289,518.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,379,700.00	9,920,780.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,271,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	4,548,600.00	8,147,580.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560,000.00	1,773,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	737,526.00	26,560.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	737,526.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,389,206.00	21,342,178.69
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,389,206.00	21,342,178.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-32,602,877.18	-21,324,282.90
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	747,923.76	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	747,923.76	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-747,923.76	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-33,350,800.94	-21,324,282.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	557,299,300.00	552,597,315.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	557,299,300.00	552,597,315.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	425,807,700.00	438,908,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	425,807,700.00	438,908,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,819,700.00	12,032,140.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,858,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,819,700.00	8,174,140.00

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	106,671,900.00	101,656,875.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,671,900.00	101,656,875.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	552,224,300.00	549,786,815.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,224,300.00	549,786,815.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	502,717,868.00	517,897,296.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,206,728.00	318,811,669.80
210101	Үндсэн цалин	236,038,628.00	259,005,918.80
210102	Нэмэгдэл	41,199,300.00	34,069,651.00
210104	Урамшуулал	23,968,800.00	25,736,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,018,500.00	42,588,422.51
210201	Тэтгэврийн даатгал	30,272,200.00	29,012,622.51
210202	Тэтгэмжийн даатгал	3,186,600.00	3,394,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,549,300.00	2,715,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	637,300.00	678,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,373,100.00	6,787,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,934,374.00	100,156,875.00
210301	Гэрэл, цахилгаан	3,310,458.00	3,055,190.00
210302	Түлш, халаалт	89,559,500.00	89,259,269.00
210303	Цэвэр, бохир ус	10,064,416.00	7,842,416.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,836,108.00	5,117,290.00
210401	Бичиг хэрэг	344,000.00	255,900.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	664,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	751,108.00	1,042,800.00
210404	Ном, хэвлэл	105,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, өрмүс	180,000.00	380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,855,600.00	2,774,590.00
2105	Нормативт зардал	39,418,600.00	35,185,339.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,098,400.00	2,460,800.00
210502	Хоол, хүнс	35,584,900.00	22,848,039.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	735,300.00	9,876,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,323,300.00	3,765,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	4,323,300.00	3,765,600.00
2107	Томилолт, зочны зардал	36,000.00	160,000.00
210702	Дотоод албан томилолт	36,000.00	160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,077,658.00	5,191,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	777,658.00	4,610,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	231,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,866,600.00	6,920,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,105,000.00	4,935,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,761,600.00	1,985,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,506,432.00	31,889,518.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,379,700.00	10,520,780.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,271,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,548,600.00	8,147,580.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560,000.00	2,373,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	737,526.00	26,560.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	737,526.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,389,206.00	21,342,178.69
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,389,206.00	21,342,178.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,075,000.00	2,810,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,075,000.00	2,810,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,075,000.00	2,810,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,075,000.00	2,810,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,075,000.00	2,810,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,075,000.00	-2,810,500.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,455,541.08	476,290,919.82	1,419,884,716.64	2,153,631,177.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,455,541.08	476,290,919.82	1,419,884,716.64	2,153,631,177.54
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-33,350,800.94	-33,350,800.94
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,455,541.08	476,290,919.82	1,386,058,964.44	2,119,805,425.34
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,455,541.08	476,290,919.82	1,386,058,964.44	2,119,805,425.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,455,541.08	476,290,919.82	1,386,058,964.44	2,119,805,425.34
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-21,324,282.90	-21,324,282.90
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,455,541.08	476,290,919.82	1,364,734,681.54	2,098,481,142.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	545,041,700.00	519,222,996.31	25,818,703.69	95.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	545,041,700.00	519,222,996.31	25,818,703.69	95.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,668,500.00	516,849,796.31	25,818,703.69	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,193,300.00	318,811,669.80	4,381,630.20	98.6
210101	Үндсэн цалин	258,215,200.00	259,005,918.80	-790,718.80	100.3
210102	Нэмэгдэл	39,242,000.00	34,069,651.00	5,172,349.00	86.8
210104	Урамшуулал	25,736,100.00	25,736,100.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шим	48,618,100.00	42,588,422.51	6,029,677.49	87.6
210201	Тэтгэврийн даатгал	35,042,300.00	29,012,622.51	6,029,677.49	82.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,394,000.00	3,394,000.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,715,200.00	2,715,200.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	678,800.00	678,800.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,787,800.00	6,787,800.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,633,400.00	100,156,875.00	4,476,525.00	95.7
210301	Гэрэл, цахилгаан	6,137,800.00	3,055,190.00	3,082,610.00	49.8
210302	Түлш, халаалт	88,023,600.00	89,259,269.00	-1,235,669.00	101.4
210303	Цэвэр, бохир ус	10,472,000.00	7,842,416.00	2,629,584.00	74.9
2104	Хангамж, бараа материалын зардал	5,970,900.00	5,797,790.00	173,110.00	97.1
210401	Бичиг хэрэг	255,900.00	255,900.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	664,000.00	664,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,133,800.00	1,042,800.00	91,000.00	92.0
210404	Ном, хэвлэл	686,600.00	680,500.00	6,100.00	99.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн уст	456,000.00	380,000.00	76,000.00	83.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,774,600.00	2,774,590.00	10.00	100.0
2105	Нормативт зардал	45,932,500.00	35,185,339.00	10,747,161.00	76.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,460,800.00	2,460,800.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	33,595,200.00	22,848,039.00	10,747,161.00	68.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,876,500.00	9,876,500.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,215,600.00	5,215,600.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	550,000.00	550,000.00	0.00	100.0
210602	Тавилга	900,000.00	900,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,765,600.00	3,765,600.00	0.00	100.0
2107	Томиллолт, зочны зардал	161,600.00	160,000.00	1,600.00	99.0
210702	Дотоод албан томиллолт	161,600.00	160,000.00	1,600.00	99.0

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,342,600.00	1,333,600.00	9,000.00	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	752,600.00	752,600.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	231,000.00	9,000.00	96.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7600500.00	7600500.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,615,000.00	5,615,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,985,500.00	1,985,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,373,200.00	2,373,200.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,373,200.00	2,373,200.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,373,200.00	2,373,200.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	545,041,700.00	519,222,996.31	25,818,703.69	95.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	438,908,300.00	417,566,121.31	21,342,178.69	95.1
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	438,908,300.00	417,566,121.31	21,342,178.69	95.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,133,400.00	101,656,875.00	4,476,525.00	95.8
132001	Орон нутгийн төсвөөс	106,133,400.00	101,656,875.00	4,476,525.00	95.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00	0.00	
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	0.00	
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30.00	30.00	0.00	
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	19.00	19.00	0.00	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	0.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,819,700.00	12,032,140.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,819,700.00	12,032,140.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,032,140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,858,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,858,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,819,700.00	8,174,140.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,819,700.00	8,174,140.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,271,100.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,548,600.00	8,147,580.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх		26,560.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,819,700.00	3858000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,819,700.00	3,858,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,858,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,819,700.00	8,147,580.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг эрхлэгч Ц.Чимэгсайхан, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Н.Пунсалдулам нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Багш бүр өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжиж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, сургалтын таатай орчин бүрдүүлэхэд чиглэдэг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 596,435.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,946.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,262.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,161.3 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,171.4 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал болон үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53,390.8	66,989.7	13,598.9
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	53,390.8	66,989.7	13,598.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,066,516.0	2,031,745.8	(34,770.3)
Үндсэн хөрөнгө	2,183,433.7	2,188,519.2	5,085.5
Хуримтлагдсан элэгдэл	(116,917.7)	(156,773.4)	(39,855.8)
Нийт хөрөнгө	2,119,906.9	2,098,735.5	(21,171.4)
Өр төлбөр	101.5	254.4	152.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,119,805.4	2,098,481.1	(21,324.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,119,906.9	2,098,735.5	(21,171.4)

Бараа материалын дансны үлдэгдэл 66,989.7 мянган төгрөг болж 13,598.9 мянган төгрөгөөр өссөн нь, тусгай зориулалтын материал 5,332.2 мянга, эм боох материал 2,671.8 мянга, хүнсний материал 5,475.9 мянга, бусад хангамжийн материал 5,014.8

мянган төгрөгөөр нэмэгдсэн ба урсгал төсвийн худалдан авалтаар аж ахуйн материал дээр 10,587.9 мянга, бусад хангамжийн материал дээр 8,500.0 мянган төгрөгийн эд материал худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,188,519.2 мянган төгрөг болж 5,085.5 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар 1,910.5 мянган төгрөгийн хөрөнгө, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн ирүүлсэн 3,175.0 мянган төгрөгийг өртөг бүхий тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,098,730.6 мянган төгрөг болж 21,074.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 21,074.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 697,003.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 697,003.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 91,530.6 мянган төгрөгөөр бууруулж 605,472.8 мянган төгрөгөөр анх баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 545,041.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 438,908.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 106,133.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 438,908.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 21,342.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харин орон нутгийн төсвөөс 101,656.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 4,476.5 мянган төгрөгөөр дутуу санхүүжжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 519,222.9 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 4,381.6 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 6,029.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,476.5 мянга, хангамж, бараа материалын зардлыг 173.1 мянга, нормативд зардлыг 10,747.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2020-2021 оны хичээлийн жилд нийт 30 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, нийт 8 бүлэг, 164 хүүхэд хүмүүжиж байгаа бөгөөд 2021 оны үйл ажиллагааны зардалд 545,041.7 мянган төгрөг батлагдсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн

бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 586,786.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 8,503.8 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативд зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 855,75.1 мянган төгрөгийн 57 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 605,472.8 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 60,431.1 мянган төгрөг хасаж баталснаас 438,908.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 106,133.4

мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын 104,633.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 100,156.9 мянган төгрөг зарцуулж 4,476.5 мянган төгрөг буюу 4.4 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 255.9 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 255.9 мянган төгрөг зарцуулсан нь дээрх тогтоолтой нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,825.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1769.8 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 156.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,899.6 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,778.5 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 2,522.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 255.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Төлбөрийн акт

1. Тус цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсээр нийт 5,658.9 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй тайлагнасан бөгөөд 2022 оны 01 дүгээр сард ногдох хүнсний материалыг өмнөх саруудын худалдан авалтын дундаж 3,136.4 мянган төгрөгөөр тооцон үлдээж, зөрүү 2,522.6 мянган төгрөгийг хүнсний материал илүү нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү нөөцөлсөн хүнсний материалын 2522.6 мянган төгрөгийг 2022 оны төсвөөс суутган буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.2 Зөвлөмж

1. Эх бүрдэн ХХК-тай 2021.01.20-ны өдөр дулаанаар хангах гэрээ байгуулсан бөгөөд нийт барилгын халаалтын талбайг 6472.8 м³ буюу сард 11,900.6 мянган төгрөг төлөхөөр гэрээ байгуулсан байна. Төрийн аудитын байгууллагын “Төрийн байгууллагуудын халаалтын талбай”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар тус байгууллагын барилгын халаалтын талбайг 3493.5 м³ буюу нийт 2979.3 м³-ээр зөрүүтэй тооцсоныг илрүүлсэн. Тайлант онд халаалтын гэрээг шинэчлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагын “Төрийн байгууллагуудын халаалтын талбай”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллан, цаашид 2022 оны 1 дүгээр сараас эхлэн халаалтын талбайн тооцоог тогтоосон талбайн хэмжээгээр халаалтын талбайг шинэчлэн гэрээ хийх зөвлөмжийг хүргүүлэв.

2. Тус байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг тулгахад анх 605,472.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 3 удаа тодотгож, 2021 оны 12 дугаар сард 60,431.1 мянга буюу 11.1 хувиар бууруулж 545,041.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Харин байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,476.5 мянга буюу 4.4 хувиар хэмнэсэн ч, бичиг хэргийн зардалд хэмнэлт гаргаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.6 “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” 1.9 “Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг	3	2,778.5	0	0	1	2,522.6	0	0	2	255.9

_____ оОо _____

_____ оОо _____